



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН СЭДЭВ: ТОХИЖИЛТЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН
АУДИТЫН КОД: СЭА-2024/38-ШТА-ГА

Дийлэнх сумд нь орон нутгийн төсвийн санхүүжилтээр хэрэгжихээр зохицуулагдсан тохижилт, үйлчилгээний чиг үүргийг мал нядалгаа, дулаан, цэвэр ус хангамж, бохир зайлуулах, нийтийн тээвэр зэрэг аж ахуйн чиг үүрэгтэй хамтатган ОНӨААТҮГ хэлбэрээр гүйцэтгүүлж байна

Дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: Enkhtuyaach@audit.gov.mn

Аудитын менежер Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Отгонбаяр

Утас: 70363047 Цахим хаяг: Otgonbayarts@audit.gov.mn

Аудитор Д.Чулуунцэцэг

Утас: 70363047 Цахим хаяг: Chuluuntsetsegd@audit.gov.mn

Сүхбаатар сум
2024 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
Дараах хаягаар авна уу: Цахим хуудас: www.audit.mn

Товчилсон үгийн тайлбар	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдээгдэл	5
Ерөнхий мэдээлэл	7
Нэгдүгээр бүлэг: Ихэнх сумд нь орон нутгийн төсвийн санхүүжилтээр хэрэгжихээр зохицуулагдсан тохижилт, үйлчилгээний чиг үүргийг аж ахуйн чиг үүрэгтэй хамтатган гүйцэтгүүлж байна.	8
1.1 Тохижилт, үйлчилгээний үйл ажиллагааг МУ-ын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөсөн байна.	8
1.2 Сумдын тохижилт, үйлчилгээний үйл ажиллагааны дийлэнхийг ОНӨААТҮГ, ЗДТГ-ууд хариуцан гүйцэтгэж байна.	14
Хоёрдугаар бүлэг: Хог хаягдлын хураамжийг бодитоор төлөвлөн, төвлөрүүлэхгүй байгаа нь төсвийн ачааллыг нэмэгдүүлж байна.	19
2.1 Хог хаягдлын хураамжийг тогтоосон үнэ тарифаар тооцож бус урьд оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөн, төвлөрүүлж байна.	19
2.2 Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг холбогдох аргачлалын дагуу тогтоогоогүй, тогтоосон үнэ тарифыг мөрдөөгүй нь орлого нэмэгдүүлэх нөөц боломжийг алдагдуулж байна.	
Гуравдугаар бүлэг: Холбогдох байгууллагуудаас тохижилт, үйлчилгээний үйл ажиллагааг тусгайлан үнэлж дүгнээгүй, үр нөлөө бүхий дотоод хяналт хийгдээгүй байна.	
3.1 Зүүнбүрэн, Түшиг, Хушаат сумын тохижилт, үйлчилгээний үйл ажиллагааны үр дүнг иргэд “Хангалтгүй” гэж үнэлсэн байна.	
3.2 Тохижилт, үйлчилгээний үйл ажиллагаанд тусгайлан дотоод аудит, хяналт, шалгалт хийгдээгүй байна.	
Аудитын дүгнэлт	21
Зөвлөмж	22

Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШТС	Шатахуун түгээх станц

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ	
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” А/100 дугаар тушаал, Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г үндэслэн Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.
Аудитын зорилт:	Сумдын тохижилт, үйлчилгээний үйл ажиллагааны үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: <i>1.Орон нутгаас тохижилт, үйлчилгээний чиглэлээр баримталж буй бодлого оновчтой байна уу?</i> <i>2. Тохижилт, үйлчилгээний орлогыг бодитоор төлөвлөн төвлөрүүлж, төсвийн санхүүжилтийг хүрэлцэхүйцээр хуваарилж байна уу ?</i> <i>3. Тохижилт үйлчилгээний үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлж, үнэлж, дүгнэж байна уу?</i>
Аудитын хамарсан хүрээ:	Аудитад сумдын 2021-2023 он, 2024 оны эхний хагас жилийн тохижилт, үйлчилгээний үйл ажиллагаа, төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, хог хаягдлын хураамжийн орлого, хуваарилалт, тохижилтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой баримт, материалуудыг хамруулав.
Аудитын арга зүй:	Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС- 100, АДБОУС- 300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит.Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит.Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит.Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглав.

Аудитын шалгуур, үзүүлэлт:	Аудитад дараах хууль эрх зүйн актыг гол шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд: • Төсвийн тухай хууль, • Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, • Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, • Захиргааны ерөнхий хууль, • Зөвшөөрлийн тухай хууль, • Хог хаягдлын тухай хууль, • Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, • Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 192, А/243 дугаар тушаалаар баталсан “Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тооцох аргачлал”, “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, булшлах зардлын нэгж тарифыг тооцох аргачлал”, • Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/445 дугаар тушаалаар баталсан “Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах, үйл ажиллагаа явуулах, хаах аргачилсан заавар”, • Сумдын ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж, холбогдох бусад хууль, эрх зүйн актууд.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:	Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор Ц.Отгонбаяр, аудитор Д.Чулуунцэцэг нар 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 20-ны хооронд хийж, гүйцэтгэв.

Ерөнхий мэдээлэл:	Сэлэнгэ аймгийн хэмжээний нийт 17 сумаас 8 сум нь тохижилт, үйлчилгээний үйл ажиллагааг мал нядалгаа, дулаан, цэвэр ус хангамж, бохир зайлуулах, нийтийн тээвэр зэрэг бусад чиг үүрэгтэй хавсруулан гүйцэтгүүлэхээр 9 ОНӨААТҮГ-ыг зохион байгуулсан бол 7 сум /Баруунбүрэн, Баянгол, Жавхлант, Орхон, Орхонтуул, Сант, Шаамар/-ын тохижилтын чиг үүргийг сумын ЗДТГ хариуцан гүйцэтгэж байна. Үүнээс: Түшиг, Хушаат суманд байгуулагдсан ОНӨААТҮГ-ууд нь тогтвортой үйл ажиллагаа явуулаагүй, Сайхан сумын Тохижилтын газар нь сумын ЗДТГ-аар дамжуулан санхүүжилт авч үйл ажиллагаагаа явуулж байна. Сумдын хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогын төлөвлөгөө 2021 онд 34.3 хувиар, 2022 онд 10.0 хувиар, 2023 онд 8.1 хувиар, 2024 оны эхний хагас жилд 17.0 хувиар буюу 4 жилд аймгийн дүнгээр 16.1 хувиар буюу 196.4 сая төгрөгөөр тасарч, төлөвлөсөн орлогыг биелүүлсэн тохиолдол гараагүй байна. Аймгийн дүнгээр 2021-2024 онд хог хаягдлын үйлчилгээний хураамжаас нийт 1,132.4 сая төгрөг төвлөрүүлж, тохижилт, үйлчилгээний санхүүжилтэд төсвөөс нийт 6,615.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.
--------------------------	--

Нэгдүгээр бүлэг

Ихэнх сумд орон нутгийн төсвийн санхүүжилтээр хэрэгжихээр зохицуулагдсан тохижилт, үйлчилгээний чиг үүргийг аж ахуйн чиг үүрэгтэй хамтатган гүйцэтгүүлж байна

1.1 Тохижилт, үйлчилгээний үйл ажиллагааг МУ-ын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөсөн байна

1.1.1 УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа 2050-д хог хаягдлыг ангилан ялгах, эргэлтэд оруулах, дахин боловсруулах, байгаль орчинд халгүй аргаар устгах, эдгээр зориулалтын барилга байгууламжуудыг үе шаттайгаар байгуулах, ногоон байгууламж бүхий талбай, гэрэлтүүлэг, камержуулалтыг нэмэгдүүлэх гэх зэрэг тохижилт, үйлчилгээний чиглэлийн бодлогыг тодорхой тусгасан байна.

1.1.2 “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын баримт бичигтэй нийцүүлэн Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2020-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тохижилт, үйлчилгээний талаар баримтлах бодлого, чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт

3.2.9

- 3.2.9.1. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, дадал хэвшлийг бий болгох сургалт зохион байгуулна.
- 3.2.9.2. Хог хаягдлын ангилан ялгалт, дахин боловсруулалт, эргүүлэн ашиглах үйлдвэр байгуулах санал санаачилгыг дэмжин, орчны бохирдлыг бууруулах

5.1.4,
5.1.5

- 5.1.4.1. “Био жорлон”-гийн талаарх ойлголтыг иргэдэд олгох сургалт, сурталчилгаа зохион байгуулна. “Био жорлон” суурилуулах айл өрх, аялал жуулчлалын газруудын судалгааг гаргах. Гэр хорооллын болон аялал жуулчлалын бүсэд “Био жорлон” арга хэмжээг зохион байгуулж, хөрсний бохирдлыг бууруулах
- 5.1.5.1. Төв суурин газрын ногоон төгөл, ногоон байгууламжийн судалгаа гаргах, ногоон байгууламж, төгөл байгуулах
- 5.1.5.2. Гудамж талбайн гэрэлтүүлэг хийх газруудын судалгааг гаргах, суурилуулах

5.1.6

- 5.1.6. Агаар, орчны бохирдлын эх үүсвэр, хор уршиг, сөрөг нөлөөллийн талаар олон нийтэд мэдээлж, зөв дадалд сургана.

Сэлэнгэ аймгийг 2020-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд

6.3.3 Хог хаягдлын ангилан ялгалт, дахин боловсруулалт, эргүүлэн ашиглах үйлдвэр байгуулах санал санаачилгыг дэмжин, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээ авч ажиллана.

6.3.4. Аймгийн хэмжээнд агаар, орчны бохирдлын эх үүсвэр, хор уршиг, сөрөг нөлөөллийн талаар олон нийтэд мэдээлэл өгч, зөв дадал хэвшилд сургах, иргэний байгаль орчныг хамгаалах сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулна.

6.3.5 Аюултай хог хаягдлыг түр хадгалах, устгах зориулалттай байгууламж барьж, сөрөг нөлөөг бууруулна.

6.3.7 Байгууллага бүрт “Ногоон оффис” төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.1.3 Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан 17 сумдын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тохижилт, үйлчилгээний чиглэлийн арга хэмжээг тус тус төлөвлөсөн байна.

1.2 Сумдын тохижилт, үйлчилгээний үйл ажиллагааг ихэвчлэн ОНӨААТҮГ, ЗДТГ-ууд хариуцан гүйцэтгэж байна

1.2.1 Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д заасан сумын чиг үүрэгт тохижилт, үйлчилгээний чиглэлээр дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр заасан байдаг. Үүнд:

22.1.13: Нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, ногоон байгууламжийн ашиглалт, хамгаалалт;

22.1.15: Хог хаягдлын цэгийн байршил, энгийн хог хаягдлын менежмент;

22.1.21: Суурин газрын гэрэлтүүлэг, арчлалт.

1.2.2 Мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-д “Аймаг, сум, нийслэл, дүүрэг нь хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулж болно” гэж заасны дагуу дараах 8 сум нь тохижилт, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулах ОНӨААТҮГ-уудыг сумын ИТХ болон ИТХТ-ийн тогтоолоор байгуулсан байна. Үүнд:

Хүснэгт 1. Тохижилтын чиглэлээр байгуулсан ОНӨААТҮГ-ууд

№	Сумын нэр	ОНӨААТҮГ-ын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Үүсгэн байгуулагдсан шийдвэр
1	Сүхбаатар	Өргөн Сэлэнгэ үйлчилгээ	Гэрэлтүүлэг, мал, мах нядалгаа, Сайханы хөтөл, худалдааны төвийн үйл ажиллагаа, нийтийн тээвэр	Сүхбаатар сумын ИТХ-ын 2022.03.04-ны өдрийн 38 дугаар тогтоол
2		Цагаан эрэг тохижилт үйлчилгээ	Нийтийн эзэмшил зам, талбай, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн арчлалт, хамгаалалт, ургалт усжуулалт, мод үржүүлэг, нөхөн сэргээлт, био бордоо үйлдвэрлэх, хортон шавжтай тэмцэх, хог хаягдлыг тээвэрлэх, устгах, боловсруулах, ариутгал халдваргүйжүүлэлт	Сүхбаатар сумын ИТХ-ын 2022.03.04-ны өдрийн 39 дугаар тогтоол

3	Мандал	Тохилог Хараа	Нийтийн эзэмшлийн гудамж талбай, авто замын хог хаягдлыг цэвэрлэх, ачиж тээвэрлэх, ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг зөөж, тээвэрлэх, хог хаягдлын төвлөрсөн цэгийн үйл ажиллагаа, нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт, үйлчилгээ	Мандал сумын ИТХ-ын 2019.12.20-ны өдрийн 90 дүгээр тогтоол
4	Ерөө	Төгөлдөр Ерөө	Гудамж, талбайн гэрэлтүүлэг, засвар үйлчилгээ, нийтийн эзэмшлийн зам талбайн засвар үйлчилгээ, энгийн хог хаягдлыг цэвэрлэх, дулаан үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах, бохир ус соруулах	Ерөө сумын ИТХТ-ийн 2013.03.07-ны өдрийн 16 дугаар тогтоол.
5	Хүдэр	Хүдэр тохижилт	Зам талбайн тохижилт, ногоон байгууламж, хог хаягдал цэвэрлэх, ачиж тээвэрлэх, золбин нохой устгах, ус түгээх, усан сангийн үйл ажиллагаа	Хүдэр сумын ИТХ-ын 2017.05.12-ны өдрийн 31 дүгээр тогтоол
6	Цагааннуур	Цагааннуур тохижилт	Нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт үйлчилгээ, ногоон байгууламж, авто зам, цэвэр бохир ус, барилга байгууламжийн ашиглалт	Цагааннуур сумын ИТХТ-ийн 2021.03.23-ны өдрийн 29 дүгээр тогтоол
7	Зүүнбүрэн	Илдэн бүрэн	Нийтийн эзэмшлийн гудамж талбай, авто зам төвлөрсөн хогийн цэгийг цэвэрлэх, ачиж тээвэрлэх, гэрэлтүүлгийн ашиглалт, тохижилт үйлчилгээ, халаалтын зуух, нийтийн халуун усны үйлчилгээ эрхлэх.	Зүүнбүрэн сумын ИТХТ-ийн 2021.03.03-ны 26 дугаар тогтоол
8	Хушаат	Хушаат дуут хад	Нийтийн эзэмшлийн гудамж талбайн тохижилт үйлчилгээ, төвлөрсөн хог хаягдлын цэгийг цэвэрлэх, ачиж тээвэрлэх, нийтийн халуун усны үйлчилгээ, халаалтын зуух, хүлэмжийн аж ахуй, хүнсний ногооны зоорь ажиллуулах	Хушаат сумын ИТХТ-ийн 2021.04.26-ны өдрийн 29 дүгээр тогтоол
9	Түшиг	Мандах Зэлтэр тохижилт	Тохижилт үйлчилгээ, бүтээн байгуулалт, төсөл хэрэгжүүлэлт	Түшиг сумын ИТХТ-ийн 2021.10.11-ний өдрийн 35 дугаар тогтоол

Эх сурвалж: Сумдын ИТХ болон ИТХТ-ийн тогтоол

1.2.3 Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.2-т “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай **хуулийн дагуу сонгон шалгаруулж, гэрээ байгуулах**” гэж заасны дагуу Алтанбулаг сум нь энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулах тендер зарлан, Сэлэнгэ ундрам ХХК-ийг шалгаруулан, гэрээ байгуулснаар 2024 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн тус компани нь энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, нэгдсэн хогийн цэгийн хяналтыг сайжруулах үйл ажиллагааг гүйцэтгэж байна.

1.2.4 Харин Сайхан сумын ИТХТ-ийн 2014 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 08 дугаар тогтоолоор тохижилтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан “Дөмбөн

Сайхан” ОНӨҮГ-ыг татан буулгаж, “Хот тохижилтын газар” улсын төсөвт үйлдвэрийн газар болгон өөрчлөн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдийг улсын төсөвт үйлдвэрийн газар гэнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2.5 Дээр дурдсанаар аймгийн хэмжээний нийт 17 сумаас 8 сум нь тохижилт, үйлчилгээний үйл ажиллагааг мал нядалгаа, дулаан, цэвэр ус хангамж, бохир зайлуулах, нийтийн тээвэр зэрэг бусад чиг үүрэгтэй хавсруулан гүйцэтгүүлэхээр 9 ОНӨААТҮГ-ыг зохион байгуулсан бол 7 сум /Баруунбүрэн, Баянгол, Жавхлант, Орхон, Орхонтуул, Сант, Шаамар/-ын тохижилтын чиг үүргийг сумын ЗДТГ хариуцан гүйцэтгэж байна.

1.2.6 Сумдын тохижилтын үйл ажиллагааг гүйцэтгэж буй байгууллагуудын зохион байгуулалтын хэлбэрийг дүрслэлээр харуулбал:

Дүрслэл 1. Тохижилтын байгууллагуудын

зохион байгуулалтын хэлбэр



Дүрслэлээс харахад тохижилтын үйл ажиллагааг нийт 17 сумын 47.1 хувь нь ОНӨААТҮГ хэлбэрээр, 41.1 хувь нь сумын ЗДТГ, 5.9 хувь болох Алтанбулаг сум хувийн аж ахуйн нэгжээр, 5.9 хувь буюу Сайхан сум нь улсын төсөвт үйлдвэрийн газар хэлбэрээр тус тус зохион байгуулан гүйцэтгүүлж байна.

1.2.7 Орон нутгийн төсвийн санхүүжилтээр хэрэгжихээр зохицуулагдсан тохижилт, үйлчилгээний чиг үүрэг /хог хаягдлын менежмент, гэрэлтүүлэг, ногоон байгууламж/-ийг мал нядалгаа, дулаан, цэвэр ус хангамж, бохир зайлуулах, нийтийн тээвэр зэрэг аж ахуйн чиг үүрэгтэй хавсруулан ОНӨААТҮГ хэлбэрээр зохион байгуулан гүйцэтгүүлж байгаа нь төсвийн санхүүжилтийг бусад чиг үүрэгт зориулалт бусаар зарцуулах эрсдэлийг үүсгэж байна.

Хоёрдугаар бүлэг

Хог хаягдлын хураамжийг бодитоор төлөвлөн төвлөрүүлэхгүй байгаа нь төсвийн ачааллыг нэмэгдүүлж байна

2.1 Хог хаягдлын хураамжийг тогтоосон үнэ тарифаар тооцолгүйгээр урьд оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөн, төвлөрүүлж байна

2.1.1 Тохижилт, үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааны орлогын үндсэн эх үүсвэр нь иргэн, аж ахуйн нэгжүүдээс сумын төсөвт төвлөрүүлж буй хог хаягдлын үйлчилгээний хураамж юм.

2.1.2 Дараах хуулиудаар иргэн, аж ахуйн нэгжээс хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоосон үнэ тарифаар сумын төсөвт төвлөрүүлж, тохижилтын үйл ажиллагаа буюу хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, булшлах үйл ажиллагааг санхүүжүүлэхээр зохицуулсан байдаг. Үүнд:

- ✓ Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8-д “Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараах эх үүсвэрээс бүрдэнэ”, 23.8.12: “Хог хаягдлын үйлчилгээний хураамж”,
- ✓ Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйл “Сумын чиг үүрэг”-ийн 22.1.4-д “Хууль тогтоомжид заасан хүрээнд албан татвар, төлбөр хураамжийн хувь хэмжээг тогтоох”,
- ✓ Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.4-д “Хог хаягдлын үйлчилгээний хураамжаас төвлөрсөн орлогыг энэ хуулийн 41.9-д заасны дагуу зарцуулах”, 41.9: “Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг дараах үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулна”, 41.9.1: “Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх”, 41.9.2: “Хог хаягдлыг булшлах” гэх мэт.

2.1.3 Аудитаар сумдын хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төлөвлөлт, гүйцэтгэлийг тулган шалгаж, хүснэгтээр нэгтгэн харуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт 2.

Сумдын 2021-2024 оны хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

№	Сумдын нэр	2021		2022		2023		2024 оны хагас жил		Нийт дүн		Зөрүү	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	Алтанбулаг	45.0	12.2	26.5	17.7	16.5	11.5	10.0	7.6	98.0	49.0	(49.0)	50.0
2	Баруунбүрэн	2.0	1.8	2.0	1.7	2.0	1.7	3.0	0.6	9.0	5.9	(3.1)	65.1
3	Баянгол	10.0	13.7	10.0	18.2	12.0	11.2	5.0	3.8	37.0	46.9	9.9	126.7
4	Ерөө	-	4.7	25.0	14.4	25.0	19.1	18.0	9.2	68.0	47.4	(20.6)	69.8
5	Жавхлант	1.5	1.2	1.5	1.5	2.0	0.6	0.5	1.1	5.5	4.5	(1.0)	81.3
6	Зүүнбүрэн	3.0	3.3	6.0	7.0	2.1	3.5	4.0	-	15.1	13.7	(1.3)	91.3
7	Мандал	80.0	80.2	150.0	145.2	150.0	150.6	75.0	81.8	455.0	457.8	2.8	100.6
8	Орхон	2.0	1.3	2.0	-	2.0	-	3.5	0.7	9.5	2.0	(7.5)	21.1
9	Орхонтуул	4.5	3.5	4.0	1.2	4.0	2.2	5.0	4.4	17.5	11.3	(6.2)	64.4
10	Сайхан	40.0	31.1	64.0	35.0	34.0	61.1	40.2	51.2	178.2	178.4	0.2	100.1
11	Сант	8.0	2.3	-	-	2.0	0.5	0.5	0.8	10.5	3.7	(6.8)	34.8
12	Сүхбаатар	95.0	66.3	65.0	63.7	120.0	94.0	60.0	34.1	340.0	258.2	(81.8)	75.9
13	Түшиг	3.0	3.0	-	-	2.0	0.3	0.1	-	5.1	3.3	(1.8)	65.4
14	Хушаат	3.5	2.9	6.6	4.1	6.6	4.9	3.8	1.4	20.5	13.2	(7.3)	64.5
15	Хүдэр	2.0	3.1	-	0.6	10.0	0.7	2.5	3.3	14.5	7.8	(6.7)	53.7
16	Цагааннуур	2.5	2.5	6.0	2.8	4.0	2.6	2.0	0.2	14.5	8.1	(6.4)	55.6
17	Шаамар	8.0	9.6	6.0	5.5	8.5	5.7	8.5	0.5	31.0	21.4	(9.6)	69.0
	Нийт дүн	310.0	242.8	374.6	318.6	402.7	370.2	241.6	200.8	1,328.9	1,132.4	(196.4)	85.2

Эх сурвалж: Сумдын төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлан

2.1.4 Хүснэгтээс харахад сумдын хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого 2021 онд 34.3 хувиар, 2022 онд 10.0 хувиар, 2023 онд 8.1 хувиар, 2024 оны эхний хагас жилд 17.0 хувиар буюу 4 жилд аймгийн дүнгээр 16.1 хувиар буюу 196.4 сая төгрөгөөр тасарч, орлогын гүйцэтгэл хангалтгүй байна.

2.1.5 Сумдын хувьд сүүлийн 4 жилийн дүнгээр Сайхан, Мандал, Баянгол сумд тус тус 0.1-26.7 хувиар давуулан биелүүлсэн бол бусад сумд 8.7-78.9 хувиар тасалсан байна.

2.1.6 Сумдын хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогын төлөвлөгөө жил дараалан тасрах, төлөвлөсөн орлого бүрэн төвлөрөхгүй байхад дараах хүчин зүйлүүд нөлөөлж байна. Үүнд:

- ✓ Бугант, Түнхэл, Номгон, Рашаант зэрэг тосгод нь хог хаягдлын үйлчилгээний хураамжийг огт төвлөрүүлдэггүй,
- ✓ Хог хаягдлын хураамжийн орлогыг тогтоосон үнэ тарифаар тооцолгүйгээр урьд оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөж, төвлөрүүлдэг,
- ✓ Сумд Хог хаягдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2¹-т заасны дагуу хог хаягдлын хураамжийг хураах эрх бүхий албан тушаалтныг томилоогүй, хураамжийн авлага, өглөгийг тооцдоггүй,
- ✓ Орлогын байцаагчийн цалин хөлсийг хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогын бүрдүүлэлттэй уялдуулан тооцож олгохоор хөдөлмөрийн гэрээг байгуулаагүй, цалинг сар бүр тогтмол олгодог,
- ✓ Алтанбулаг сум нь 2024 онд хог хаягдлын үйлчилгээний хураамжийн 4.6 сая төгрөгийг сумын төсөвт бус “Алтанбулаг сум дахь тохижилт, үйлчилгээний төслийн хамтран ажиллах” гэрээний дагуу ажиллаж байгаа Сэлэнгэ-Ундром ХХК-ийн дансанд төвлөрүүлсэн,
- ✓ Мөн Алтанбулаг сум нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.12²-т заасны дагуу хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогод төвлөрөх нийт 208.0 сая төгрөгийн орлогыг Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3³-т заасан бичил худалдаа, ажил, үйлчилгээ эрхлэгчийн татварын орлогын дансанд төвлөрүүлсэн байна. Үүнд: 2021 онд 21.7 сая төгрөг, 2022 онд 75.9 сая төгрөг, 2023 онд 57.5 сая төгрөг, 2024 онд 52.9 сая төгрөг гэх мэт.

2.1.9 Аудитад хамрагдаж буй 2021-2024 онуудын хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогын гүйцэтгэл, төсвөөс хот тохижуулалтад хуваарилсан санхүүжилтийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 3.

Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого төвлөрүүлэлт, төсвөөс хот тохижуулах үйл ажиллагаанд хуваарилсан санхүүжилт
/сая төгрөгөөр/

¹ “Сум, дүүргийн Засаг дарга, орон нутгийн зэрэглэлтэй хотын Захирагч хог хаягдлын хураамжийг хураах эрх бүхий албан тушаалтныг томилон ажиллуулна;”

² “ хог хаягдлын үйлчилгээний хураамж;”

³ “бичил худалдаа, ажил, үйлчилгээ эрхлэгч” гэж ажлын байр, лангуу зэрэг тодорхой байршилд байрлахгүй худалдаа, үйлчилгээ, зорчигч болон ачаа тээврийн үйлчилгээ эрхлэгч хувь хүнийг”

№	Сумдын нэр	2021		2022		2023		2024 оны хагас жил		Нийт дүн		Зөрүү
		Төвлөрүүлсэн орлого	Санхүүжүүлсэн дүн	Төвлөрүүлсэн орлого	Санхүүжүүлсэн дүн	Төвлөрүүлсэн орлого	Санхүүжүүлсэн дүн	Төвлөрүүлсэн орлого	Санхүүжүүлсэн дүн	Төвлөрүүлсэн орлого	Санхүүжүүлсэн дүн	
1	Алтанбулаг	12.2	8.6	17.7	27.5	11.5	47.0	7.6	15.3	49.0	98.4	(49.42)
2	Баруунбүрэн	1.8	1.8	1.7	1.7	1.7	1.7	0.6	0.6	5.9	5.8	0.06
3	Баянгол	13.7	7.0	18.2	10.0	11.2	31.2	3.8	15.5	46.9	63.7	(16.82)
4	Ерөө	4.7	23.9	14.4	78.1	19.1	102.5	9.2	58.7	47.4	263.2	(215.77)
5	Жавхлант	1.2	3.0	1.5	5.0	0.6	8.0	1.1	4.0	4.5	20.0	(15.53)
6	Зүүнбүрэн	3.3	4.0	7.0	6.4	3.5	6.8	-	0.3	13.7	17.5	(3.75)
7	Мандал	80.2	411.6	145.2	666.6	150.6	788.6	81.8	544.8	457.8	2,411.6	(1,953.84)
8	Орхон	1.3	-	-	-	-	-	0.7	-	2.0	-	2.01
9	Орхонтуул	3.5	2.0	1.2	3.9	2.2	4.5	4.4	5.2	11.3	15.6	(4.32)
10	Сайхан	31.1	229.8	35.0	261.9	61.1	500.5	51.2	234.8	178.4	1,227.0	(1,048.61)
11	Сант	2.3	1.3	-	-	0.5	0.5	0.8	-	3.7	1.8	1.85
12	Сүхбаатар	66.3	319.7	63.7	642.9	94.0	845.8	34.1	562.5	258.2	2,370.9	(2,112.74)
13	Түшиг	3.0	2.7	-	1.6	0.3	0.9	-	1.1	3.3	6.3	(2.97)
14	Хушаат	2.9	2.7	4.1	2.7	4.9	2.7	1.4	2.1	13.2	10.2	3.02
15	Хүдэр	3.1	2.3	0.6	4.7	0.7	30.0	3.3	12.6	7.8	49.6	(41.82)
16	Цагааннуур	2.5	10.0	2.8	10.1	2.6	10.0	0.2	9.7	8.1	39.8	(31.74)
17	Шаамар	9.6	4.6	5.5	5.3	5.7	3.5	0.5	0.8	21.4	14.2	7.19
	Нийт дүн	242.8	1,035.0	318.6	1,728.4	370.2	2,384.2	200.8	1,468.0	1,132.4	6,615.6	(5,483.19)

2.1.10 Хүснэгтээс харахад 2021-2024 онд аймгийн дүнгээр хог хаягдлын үйлчилгээний хураамжаас нийт 1,132.4 сая төгрөг төвлөрүүлж, тохижилт, үйлчилгээний санхүүжилтэд төсвөөс нийт 6,615.6 сая төгрөг олгосон байна.

2.1.11 Өөрөөр хэлбэл тохижилт үйлчилгээнд төсвөөс олгох санхүүжилтийг жил бүр өсгөж байгаа боловч санхүүжилтийн үндсэн эх үүсвэр болсон хог хаягдлын хураамжийн тарифыг үнийн инфляцтай уялдуулан шинэчлэн тогтоохгүй байгаа нь төсөвт үүсэх ачааллыг нэмэгдүүлж байна.

2.2 Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг холбогдох аргачлалын дагуу тогтоогоогүй, тогтоосон үнэ тарифыг мөрдөөгүй нь орлого нэмэгдүүлэх нөөц боломжийг алдагдуулж байна

2.2.1 Тохижилт үйлчилгээний байгууллагуудын орлогын үндсэн эх үүсвэр болсон сумын төсвийн хог хаягдлын хураамжийг хууль, эрх зүйн актын хүрээнд үнэн зөв, бодитой, нөөц боломжийг бүрэн дүүрэн ашиглан төлөвлөж, хэрэгжүүлбэл хот тохижилтын байгууллагуудын орлого нэмэгдэх, энэ хэрээр тохижилт, үйлчилгээний чанар, хүртээмж, үр дүн сайжрах боломжтой байна.

2.2.2 Аудитын явцад хог хаягдлын хураамжийн орлогыг нэмэгдүүлэх нөөц боломжийг үнэ тарифын тогтоолт, түүний мөрдөлтийн хүрээнд авч үзлээ.

2.2.3 Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1⁴ дахь заалтыг үндэслэн Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 192, А/243 дугаар хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралтаар “Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тооцох аргачлал”, 2 дугаар хавсралтаар “Энгийн хог

⁴ “энэ хуулийн 8.7.2-т заасан аргачлалын дагуу энгийн хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх, зардлын нэгж тарифыг батлах;”, “8.7.2.энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, булшлах зардлын нэгж тарифыг тооцох аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах;”

хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, булшлах зардлын нэгж тарифыг тооцох аргачлал”- ыг тус тус баталсан байна.

2.2.4 Хог хаягдлын тухай хуулийн 9.2.2 ⁵ дахь заалтад сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь батлагдсан аргачлалыг ашиглан нутаг дэвсгэртээ мөрдөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тогтоохоор зохицуулсан байдаг. Уг заалтын дагуу хог хаягдлын үнэ тарифыг тогтоосон байдлыг хүснэгтээр харуулбал:

Сумдын хог хаягдлын хураамжид мөрдөж буй үнэ тариф

/ төгрөгөөр /

№	Сумдын нэр	ИТХ-аар тогтоосон хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээ													
		ИТХ-ын тогтоолын огноо	ИТХ-ын тогтоол-ын дугаар	Айл өрх	Аж ахуйн нэгж байгуул-лага	Нэг иргэн	Аж ахуйн нэгж м2, үйлчлүү лэг-чийн тоогоор	Үйлдвэр-лэл эрхлэгч нэгж бүтээгд-хүүн	Нийтийн эзэмш-лийн гудамж талбайн м2,	Барил-гын хог хаягдал м2	Булж устгах авто-машин-даацаар	Чөлөөт бүсрүү зорчсон авто-машин бүрээс	Хилээр нэвтэрч буй том оврийн ачаа тээврийн авто-машин бүрээс	Худал-даа үйлчил-гээ эрхлэгч иргэн	Бусад үйлд-вэрлэл, ААН
1	Алтанбулаг	2022.10.24	77	3,000	25,000							1,000	21,000	10,000	
2	Баруунбүрэн	2013.04.01	30	500	2000-4000				6,000						
3	Баянгол	2021.09.30	28	1000-5000	10000-120000									10000-60000	50000-250000
4	Ерөө	2021.05.10	30			530	820-99000	200-165000	17,000						
5	Жавхлант	2013.07.24	15	1,000											
6	Зүүнбүрэн	2022.09.30	27	1,000	5000-30000									5,000	50000-100000
7	Мандал	2019.01.30	74	2,000			1000-50000	8000-100000		300-20000					
8	Орхон	2022.05.17	35	5,000	15,000				10,000						
9	Орхонтуул	2019.06.19	96	1000-2000	5000-50000										
10	Сайхан	2022.12.20	53	7,000	30,000										
11	Сант	2024.05.29	103	10000-15000	10000-15000				15,000						
12	Сүхбаатар	2022.06.22	44	3,000	5000-20000		10000-25000								
13	Түшиг	2012.06.19	19	1,000			2000-5000								
14	Хушаат	2024.02.28	2												15,000
15	Хүдэр	2023.08.22	131	5,000	5000-30000			5000-150000							
16	Цагааннуур	2019.02.25	69	2,000	5000-8000										
17	Шаамар	2024.09.09	26	1000-2000	5,000										

2.2.5 Сумууд хог хаягдлын нормативт дээд хязгаар болон зардлыг иж бүрэн тооцолгүйгээр буюу хог хаягдлын хураамжийн үнэ тарифыг холбогдох аргачлалын дагуу тогтоохгүй байгаа нь тохижилт, үйлчилгээний орлогыг нэмэгдүүлэх нөөц боломжийг алдагдуулах нэг нөхцөл болж байна. Үүнд:

- ✓ Хог хаягдлын тухай хуулийн 41.6⁶-д заасны дагуу айл өрхийн хэрэглээнээс үүсэх энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг нэг иргэнээр бус өрхийн тоогоор тооцсон,
- ✓ Баруунбүрэн, Ерөө, Орхон, Сантаас бусад сумд нь Хог хаягдлын тухай хуулийн 41.3⁷ -т заасан овор хэмжээ ихтэй болон барилгын хог хаягдлыг тээвэрлэх, устгах үйлчилгээний хөлсийг тооцож батлаагүй,

⁵ “энэ хуулийн 8.7.1-д заасан аргачлалын дагуу тухайн нутаг дэвсгэрт мөрдөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тогтоох.”

⁶ “Айл өрхийн хэрэглээнээс үүсэх энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг нэг иргэнээр тооцно”

⁷ “Овор хэмжээ ихтэй болон барилгын хог хаягдлыг тээвэрлэх, устгах үйлчилгээний хөлс нь энэ хуулийн 41.1-д заасан хураамжид хамаарахгүй.”

- ✓ Мандал сумаас бусад сумд нь өөрийн үүсгэсэн хогийг төвлөрсөн хогийн цэгт хувийн тээврийн хэрэгслээр тээвэрлэн хүргэсэн тохиолдолд хог хаягдлыг дарж булшлах үйлчилгээний хураамжийн үнэ тарифыг тооцож тогтоогоогүй,
- ✓ Ерөө сумаас бусад сумд нь Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2⁸-т заасан нутаг дэвсгэрт хамаарах олон улсын, улсын, орон нутгийн чанартай замын дагуух хог хаягдал болон нийтийн эзэмшлийн зам талбайг цэвэрлэхэд шаардлагатай хог хаягдлын үйлчилгээний хураамжийн үнэ тарифыг батлагдсан журам аргачлалын дагуу тооцож тогтоогоогүй,
- ✓ Баруунбүрэн, Жавхлант, Түшиг зэрэг сумд нь 2012-2013 онд баталсан, “Хог хаягдлын норматив, хог хаягдал үүсгэсний төлбөрийн хэмжээ”-г мөрдөж байгаа бөгөөд үнэ тарифыг шинэчлэн тогтоогоогүй гэх мэт.

2.2.6 Хог хаягдлын үнэ тарифын тогтоолтод оршиж буй зөрчлүүдээс шалтгаалан сумдын тохижилт, үйлчилгээний үйл ажиллагаанд дараах сөрөг үр дагаврууд үүсэж байна.

- ✓ Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг шинэчлэн батлагдсан журам, аргачлалын дагуу бодитой тогтоогоогүйгээс орон нутгийн төсөвт төвлөрөх орлого бүрэн төвлөрөхгүй байх, тохижилтын байгууллагын ажил, үйлчилгээний зарим арга хэмжээ хэрэгжихгүй байх,
- ✓ Иргэн, ААН-үүд нь тохижилтын байгууллагатай “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, **булшлах** үйлчилгээний гэрээ”-г байгуулахгүйгээр төвлөрсөн хогийн цэгт энгийн болон овор ихтэй хог асгаснаас хог хаягдал ихээр хуримтлагдаж, улмаар төсвийн хөрөнгөөр төвлөрсөн хогийг дарж, нягтруулан булшлах ажлыг гүйцэтгэж төсвийн ачааллыг нэмэгдүүлэх гэх мэт.


2.2.7 Сумууд хог хаягдлын хураамжийн орлогыг төлөвлөхдөө ИТХ-аар баталсан үнэ тариф болон үйлчилгээ үзүүлэх иргэн аж ахуйн нэгжийн тоо мэдээлэлд үндэслэлгүйгээр зөвхөн өмнөх оны гүйцэтгэлийг үндэслэн төлөвлөж ирсэн байна.

2.2.8 Аудитын явцад сумдын хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогын батлагдсан төлөвлөгөөг аудитад хамрагдаж буй 2021-2024 онуудад мөрдөгдөж буй үнэ тариф, жилийн эцсийн хүн ам, аж ахуйн нэгжийн статистик тоо мэдээлэлд үндэслэн давтан тооцсон орлоготой харьцуулан дүрслэлээр харуулахад дараах байдалтай байна.

Дүрслэл 2.

/сая төгрөгөөр/

⁸ “Энэ хуулийн 8.7.1-д заасан аргачлалын дагуу тухайн нутаг дэвсгэрт мөрдөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тогтоох.”



Эх сурвалж: Сумдын 2021-2024 ИТХ-ын тогтоол, хүн амын статистик мэдээ

2.2.10 Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг батлагдсан үнэ тариф, хүн амын статистикийн мэдээнд үндэслэн тооцоход аймгийн дүнгээр хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг нийт 3,368.5 сая төгрөгөөр төлөвлөх боломжтой атал 1,328.9 сая төгрөгийн орлогыг төлөвлөн батлуулж, 2,039.6 сая төгрөгийн орлогыг дутуу төлөвлөсөн байна.

2.2.11 Нөгөө талаас сумд нь 2012-2021 онуудад тогтоосон үнэ тарифыг мөрдөж байгаа бөгөөд бараа, бүтээгдэхүүний зах зээлийн үнийн өсөлттэй уялдуулан хог хаягдлын үйлчилгээний үнэ тарифыг шинэчлэн тогтоогоогүй нь орлого нэмэгдэх нөөц боломжийг алдагдуулж байна.

Гуравдугаар бүлэг

Холбогдох байгууллагуудаас тохижилт, үйлчилгээний үйл ажиллагааг тусгайлан үнэлж дүгнээгүй, үр нөлөө бүхий дотоод хяналт хийгдээгүй байна

3.1 Зүүнбүрэн, Түшиг, Хушаат сумдын тохижилт, үйлчилгээний үйл ажиллагааны үр дүнг иргэд “Хангалтгүй” гэж үнэлсэн байна

3.1.1 Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд тусгагдсан тохижилт, үйлчилгээний чиглэлийн зорилт, арга хэмжээг аймаг, сумд дараах байдлаар хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- ✓ Хог хаягдлын ангилан ялгалт, дахин боловсруулалт, эргүүлэн ашиглах үйлдвэр байгуулах санал санаачилгыг дэмжин, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээний хүрээнд Сүхбаатар суманд уг чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг Хэт жолоо ХХК-д 10.0 сая төгрөгийн хог хаягдлыг пресслэх төхөөрөмжийг гэрээгээр эзэмшүүлсэн байна. Тус компани үйл ажиллагаагаа өргөжүүлэн Сайхан, Хүдэр, Түшиг, Зүүнбүрэн сумдад салбаруудаа байгуулан, ажлын байр бий болгож, сумын хог хаягдлыг

бууруулах, агаар, хөрсний бохирдлыг багасгахад тодорхой хувь нэмэр оруулсан байна.



Хэт жолоо ХХК-ийн ажлын байр

- ✓ Сэлэнгэ аймгийн Засаг даргын “Эрүүл аюулгүй-Цэвэр орчин” бүрдүүлэх албан даалгаварт ариун цэврийн байгууламжийг сайжруулах ажлыг тусган гэр хорооллын айл өрхийн нүхэн жорлон, угаадасны нүхний тооллого зохион байгуулж, хөрсний бохирдлыг бууруулах, эко жорлонтой болгох үүрэг чиглэл хүргүүлэн 22 нүхэн жорлонг буулгаж, Баруунбүрэн 2, Мандал 4, Алтанбулаг 2 био жорлон, Сүхбаатар сумын “Шунхлай” ШТС 1 боловсон 00-той болсон байна.
- ✓ Сүхбаатар сумын 1-р багийн нутаг “Хонгор морьт”-д аюултай хог хаягдлыг түр хадгалах, агуулах, барих ажлыг “Цомбон тоосго” ХХК-иар хийлгүүлэн, ашиглалтад оруулж, аймгийн хэмжээнд 5542.4 тн аюултай хог хаягдал тоологдсоныг цуглуулж устгуулсан байна.
- ✓ Аймгийн албан ёсны цахим хуудсаар дамжуулан “Агаар, орчны бохирдлын эх үүсвэр, хор уршиг, сөрөг нөлөөлөл”-ийн талаар олон нийтэд 2 удаагийн мэдээлэл өгч, “Байгаль орчныг хамгаалах журамт үүргийг таниулахад чиглэсэн сургалт”-ыг аймгийн Ерөнхий боловсролын 35 сургуулийн 1500 хүүхэд, 17 сум 6 тосгоны 2000 иргэдийг оролцуулан зохион байгуулж, 530 ширхэг сурталчилгааны материалыг тараан зөв дадал хэвшилд сургах ажлыг хийсэн.
- ✓ Аймгийн хэмжээнд “Ногоон сум” шалгаруулах удирдамжийг ногоон хөгжлийн бодлоготой уялдуулснаар 17 сум, 6 тосгоны 5219 иргэн, 545 аж ахуйн нэгж, байгууллага мод тарих ажилд оролцож, 7887 м² цэцгийн мандал, 5976 м² талбайд зүлэгжүүлэлт, 5,5 га талбайд цэцэрлэгт хүрээлэн, 6 нэрэмжит төгөл байгуулж, 9,3 сая ширхэг тарьц ургуулан, тохижилт, ногоон байгууламж сайтай сумаар Мандал, Зүүнбүрэн, Баянгол сумдыг шалгаруулсан байна. Уг аянд 1200 айл өрхийг оролцуулж, иргэдийг ая тухтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлсэн байна.



Баянгол сумын цэцэрлэгт хүрээлэн- Ногоон зүлэг суулгаж, мод тарьж, цэцэрлэгжүүлэн тохижуулсан байдал

- ✓ Аймаг, сумдын хөрөнгө оруулалт болон ОНХС-ийн хөрөнгөөр 2021-2024 оны эхний хагас жилд 11 суманд 2,525.1 сая төгрөгийн гэрэлтүүлэг шинээр тавьсан байна.

Тухайлбал 2023 онд ОНХО-аар 5 суманд 852.2 сая төгрөгийн, ОНХС-ийн эх үүсвэрээр 7 суманд 460.0 сая төгрөгийн гэрэлтүүлэг шинээр нэмэгдсэн гэх мэт.

3.1.2 Аймаг, сумдын ОНХС, улсын болон ОНХО-ын эх үүсвэрээр 2021-2024 онуудад хот тохижилтын байгууллагуудад нийт 3,776.3 сая төгрөгийн балансын үнэ бүхий 69 тээврийн хэрэгсэл нийлүүлэгдэж, дараах чиглэлүүдээр ашиглагдаж байна. Үүнд:

- ✓ Жавхлант, Орхоноос бусад сумдад хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх зориулалтаар портер, бонго, Зил 130, Кама, Хово маркийн нийт 32 ширхэг өөрөө буулгагч автомашин,
- ✓ Алтанбулаг, Баруунбүрэн, Жавхлант, Түшиг, Ерөөгөөс бусад сумд хог түрж, булах, зам, даваа засах зориулалттай 12 ковш, 4 трактор,
- ✓ Бохирын автомашин 5,
- ✓ Гэрэлтүүлгийн крантай автомашин 4,
- ✓ Усны автомашин 2,
- ✓ Бусад тусгай зориулалтын автомашин 10 гэх мэт.

3.1.3 Дээрх техник хэрэгслүүдээс Баянгол, Зүүнбүрэн, Орхон, Сант, Хушаат зэрэг 5 сумдын ковшийг ажиллуулах боловсон хүчин байхгүйгээс бүрэн ашиглаж чадахгүй байна.

3.1.4 Төсвийн хөрөнгө оруулалт болон төсөл, хөтөлбөрийн хөрөнгийн эх үүсвэрээр Тохилог хараа ОНӨААТҮГ-т тус бүр 40.0 сая төгрөгийн өртөг бүхий хуванцар пресслэх болон шон хэвлэгч, Өргөн Сэлэнгэ үйлчилгээ ОНӨААТҮГ-т 13.0 сая төгрөгийн хуванцар пресслэгч, Цагаан эрэг тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-т 20.0 сая төгрөгийн хог хаягдлыг бутлагч, пресслэгч, Сайхан сумын Хот тохижилтын газарт 10.0 сая төгрөгийн хог пресслэгч тус тус бэлтгэн нийлүүлэгдсэн боловч Тохилог хараа ОНӨААТҮГ-ээс бусад нь ашиглаагүй байна. Өргөн Сэлэнгэ үйлчилгээ ОНӨААТҮГ нь” Сайхны хөтөл”-ийн тохижилтын ажил дуусаагүйгээс / Сайханы хөтөлд байршуулна/, Цагаан эрэг тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ нь цахилгааны эх үүсвэрийг шийдээгүйгээс, Сайхан сумын Хот тохижилтын газар нь өөрийн байгууллагын хөрөнгөд бүртгэж аваагүйгээс хог пресслэх төхөөрөмжүүдийг тус тус ашиглалтад оруулаагүй байна.



3.1.5 Аудитаар тохижилтын байгууллагуудын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөхөөр 17 сумын 1838 иргэдээс google form-аар, Мандал, Сүхбаатар сумын 200 иргэдээс цаасаар санал асуулга авч дүгнэхэд:

- ✓ Сайхан, Ерөө, Баянгол сумдыг “сайн”,
- ✓ Зүүнбүрэн, Түшиг, Хушаат сумдыг “хангалтгүй”,
- ✓ Бусад 11 сумдыг “дунд” гэж хариулсан байна.

3.1.6 Мөн санал асуулгаар тохижилт, үйлчилгээний үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай арга хэмжээг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- ✓ Хүчин чадал сайтай, орчин үеийн машин техникээр хангах, тоног төхөөрөмжийг шинэчлэх,
- ✓ Хог хаягдлыг ангилж, дахин боловсруулах санал, санаачилгыг дэмжих,
- ✓ Үйлдвэрийн газрын удирдлагуудтай байгуулсан гэрээг дүгнэж, хариуцлагын тогтолцоог сайжруулах,
- ✓ Ажилчдын цалин хөлсийг нэмэх, нийгмийн баталгааг сайжруулах,
- ✓ Ажилчдыг нормын хувцас, ажлын багаж, хэрэгслээр хангах,
- ✓ Хог хаягдлын хураамжийг нэмэгдүүлэх,
- ✓ Хог хаягдлын хураамжийг сар бүр тогтмол хугацаанд нь төвлөрүүлэхэд анхаарах,
- ✓ Гудамж, талбайд хог ангилах савуудыг байрлуулах,
- ✓ Хог авах хуваарийг нээлттэй болгох, ажлаа ил тод, нээлттэй тайлагнадаг байх гэх мэт.

3.1 Тохижилт, үйлчилгээний үйл ажиллагаанд тусгайлан дотоод хяналт, шалгалт хийгдээгүй байна

3.2.1 Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, ... үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэгдсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна” гэж заасны дагуу аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь аймгийн ТЭЗ-ийн дотоод хяналтыг хэрэгжүүлж байна.

3.2.2 Тус албанаас 2023 онд Сүхбаатар, Мандал сумдад тохижилт, үйлчилгээний чиг үүргийг хэрэгжүүлж буй “Цагаан эрэг тохижилт үйлчилгээ”, 2024 онд “Тохилог хараа” ААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, дүгнэлт өгсөн байна.

3.2.3 Аудитаар санхүүгийн тайланг үнэн зөв илэрхийлээгүй, өртөг зардлыг үнэн зөв тооцоогүй, худалдан авах ажиллагааг хууль, тогтоомжийн хүрээнд зохион байгуулаагүй, хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй зэрэг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагаатай холбоо зөрчлүүдэд зөвлөмж хүргүүлсэн байна.

3.2.4 Дээрхээс бусад сумдын тохижилт үйлчилгээний үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийгдээгүй буюу дотоод аудит, хяналт шалгалтын хамрах хүрээ хангалтгүй байна.

3.2.5 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4⁹-д сумын ИТХ нь ОНӨААТҮГ-уудын үйл ажиллагаанд хяналт тавьж, гүйцэтгэлд үнэлэлт, дүгнэлт өгөхөөр зохицуулсны дагуу Цагааннуур, Түшигээс бусад сумдын ИТХ-аас тохижилт, үйлчилгээний чиг үүргийг гүйцэтгэдэг ОНӨААТҮГ-уудын үйл ажиллагааг үнэлж, дараах байдлаар дүгнэснээр бусдаар бусад сумдын тохижилт үйлчилгээний үйл ажиллагаанд чиглэсэн хяналт, шалгалт хийгдээгүй байна. Үүнд:

- ✓ Мандал сумын ИТХ нь жил бүр Тохилог хараа ОНӨААТҮГ-ын санхүүгийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, үр дүнг үнэлэн, баталгаажуулсан байна. Тус

⁹ орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих.

үйлдвэрийн газрын 2021 оны үйл ажиллагааг “Хангалтгүй”, 2022, 2023 оны үйл ажиллагааг “Хангалттай” үнэлсэн байна.

- ✓ Сүхбаатар сумын ИТХ нь 2022 онд бүтэц, зохион байгуулалтыг нь шинэчлэн зохион байгуулсан “Цагаан эрэг тохижилт, үйлчилгээ”, “Өргөн Сэлэнгэ үйлчилгээ” ОНӨААТҮГ-уудын 2023 оны үйл ажиллагааны тайланг 2024 оны 4 дүгээр сард хэлэлцсэн боловч үр дүнг үнэлж, зөвлөмж, дүгнэлт өгөөгүй байна.
- ✓ Хүдэр сумын ИТХ нь Хүдэр тохижилт ОНӨААТҮГ-ын жил бүрийн санхүүгийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, үйл ажиллагааны тайланг сонсож, үр дүнг хэлэлцэж, 2021-2023 онуудын үйл ажиллагааг тус бүр “Хангалттай” үнэлсэн байна.
- ✓ Ерөө сумын ИТХ нь Төгөлдөр Ерөө ОНӨААТҮГ-ын 2023, 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, 2023 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэн “Хангалттай” үнэлсэн байна.
- ✓ Зүүнбүрэн сумын ИТХ нь Илдэн бүрэн ОНӨААТҮГ-ын 2023 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж, “Хангалттай” үнэлсэн байна.
- ✓ Хушаат сумын ИТХ нь Хушаат дуут хад ОНӨААТҮГ-ын 2021, 2022 оны үйл ажиллагааны тайланг 2023 оны 4-р сард сонсож, хэлэлцээд, байгуулагдсанаасаа хойш тогтвортой үйл ажиллагаа явуулаагүй тул “Хангалтгүй” үнэлсэн бол 2023 оны үйл ажиллагааны тайланг сонсож, үр дүнг хэлэлцээгүй байна.
- ✓ Харин Цагааннуур, Түшиг сумдын ИТХ нь Цагааннуур тохижилт, Мандах зэлтэр тохижилт зэрэг аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, үнэлээгүй байна.

3.2.6 Сумдын Засаг дарга нар Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.7 дугаар зүйлд заасан “Хог хаягдлын тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах” чиг үүргийг хэрэгжүүлээгүй байна.

ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ

Аудитаар илэрсэн нийт **2,252.2 сая** төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

- ✓ Сумын орон нутгийн төсөвт төвлөрөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг тогтоосон тариф, өрх, аж ахуйн нэгж, хүн амын тоогоор тооцоогүйгээс 2021-2024 онуудад 2,039.6 сая төгрөгөөр дутуу төлөвлөсөн,
- ✓ Алтанбулаг сум нь 2021-2024 онд хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогод төвлөрөх нийт 208.0 сая төгрөгийн орлогыг бичил худалдаа, ажил, үйлчилгээ эрхлэгчийн татварын орлогын дансанд, 2024 онд 4.6 сая төгрөгийг Сэлэнгэ-Ундром ХХК-ийн дансанд тус тус төвлөрүүлсэн.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- ✓ “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын баримт бичигтэй нийцүүлэн аймаг, сумдын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт хот тохижилтын талаарх арга хэмжээг төлөвлөсөн байна.
- ✓ Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.2 дахь заалтыг хэрэгжүүлээгүйгээс энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагыг ТБОНӨХБАҮХА тухай хуулийн дагуу тендер зарлаж, сонгон шалгаруулаагүй байна.
- ✓ Аймгийн хэмжээний нийт 17 сумаас 8 сум нь тохижилт, үйлчилгээний үйл ажиллагааг мал нядалгаа, дулаан, цэвэр ус хангамж, бохир зайлуулах, нийтийн тээвэр зэрэг бусад чиг үүрэгтэй хавсруулан гүйцэтгүүлэхээр 9 ОНӨААТҮГ-ыг зохион байгуулан гүйцэтгүүлж байгаа нь тохижилт үйлчилгээний төсвийн санхүүжилтийг бусад чиг үүрэгт зориулалт бусаар зарцуулах эрсдэлийг үүсгэж байна.
- ✓ Сумын ИТХ нь хог хаягдлын үйлчилгээний хураамжийн үнэ тарифыг батлагдсан журам, аргачлалын дагуу тогтоогоогүй бөгөөд тогтоосон үнэ тарифыг мөрдөөгүй нь төсөвт төвлөрүүлэх орлогыг нэмэгдүүлэх нөөц боломжийг алдагдуулж байна.
- ✓ Тохижилт үйлчилгээнд төсвөөс олгох санхүүжилтийг жил бүр өсгөж байгаа боловч санхүүжилтийн үндсэн эх үүсвэр болсон хог хаягдлын хураамжийн тарифыг үнийн инфляцтай уялдуулан шинэчлэн тогтоохгүй байгаа нь төсөвт үүсэх ачааллыг нэмэгдүүлж байна.
- ✓ Сайхан сумын Хот тохижилтын газар, Өргөн Сэлэнгэ үйлчилгээ, Цагаан эрэг тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ууд нь хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн хог хаягдлыг пресслэх төхөөрөмжийг ашиглахгүй хөрөнгийн үр ашгийг бууруулж байна.
- ✓ Тохижилт үйлчилгээний үйл ажиллагаанд үр нөлөө бүхий дотоод аудит, хяналт шалгалт хийгдээгүйгээс үйлчилгээний чанар, санхүүжилтийн тогтолцоонд ахиц гарахгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Сумдын ИТХ-ын дарга нарт:


- Төсвөөс санхүүжихээр зохицуулагдсан тохижилт үйлчилгээний чиг үүргийг аж ахуйн чиг үүрэгтэй хамтатган ОНӨААТҮГ хэлбэрээр болон улсын төсөвт үйлдвэрийн газар, сумын ЗДТГ-аар гүйцэтгүүлж байгаа нь оновчтой эсэхийг хэлэлцэж, тохижилт үйлчилгээний байгууллагыг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах.
- Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх, энгийн хог хаягдлыг булшлах гэх мэт зардлын нэгж тарифыг тооцон хог хаягдлын үйлчилгээний хураамжийн үнэ тарифыг аргачлалын дагуу шинэчлэн боловсруулж,

хэрэгжүүлэх замаар төсвийн орлогыг нэмэгдүүлж, төсвийн ачааллыг бууруулах нөхцөл боломжийг бүрдүүлэх.

Сумдын Засаг дарга нарт:

- Хог хаягдлын хураамжийн орлогыг тогтоосон үнэ тариф, хүн амын тоонд үндэслэн төлөвлөх, хураамжийг хураах эрх бүхий албан тушаалтныг томилж, үйл ажиллагаанд нь хяналт тавих замаар төсөвт төвлөрөх орлогыг нэмэгдүүлэх.
- Хог хаягдлын хураамжийг огт төлөвлөж, төвлөрүүлдэггүй Бугант, Түнхэл, Номгон, Рашаант тосгоны иргэд, аж ахуйн нэгжүүдээс тогтоосон үнэ тарифаар тооцон хураамжийг төвлөрүүлж, тохижилт үйлчилгээний үйл ажиллагаанд хуваарилах.
- Тохижилт үйлчилгээний үйл ажиллагаанд төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн хог хаягдлыг пресслэх төхөөрөмж, ковш зэрэг техник хэрэгслүүдийг зориулалтын дагуу ашиглах нөхцөл боломж, дэд бүтцээр хангах арга хэмжээ авах.
- Тохижилт үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын үйл ажиллагаанд нь үр нөлөө бүхий дотоод хяналтыг хэрэгжүүлж, удирдан чиглүүлснээр иргэдийн амьдрах таатай орчныг бүрдүүлэх, сайжруулах.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА
Б.БАТМӨНХ
Ц.ОТГОНБАЯР